

ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

Нээлттэй Нийгэм Форум Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд санал, зөвлөмж боловсруулах цуврал хэлэлцүүлгийг 2013 оны 6 дугаар сард болон 2014 оны 1 дүгээр сард тус тус зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн үеэр «Гэмт хэрэг, ялын талаарх харьцуулалт», «Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд тусгагдсан эрүүгийн хариуцлага хүлээх ялын төрөл», «Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд ХЭҮК-оос өгөх санал зөвлөмж», «НҮБ-ын хүний эрхийн механизмаас өгсөн зөвлөмж ба Гэмт хэргийн тухай хуулийн төсөл» сэдвээр Н.Туяа (МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Практик судлалын тэнхимийн эрхлэгч), Д.Цэнд-Аюуш (Хууль хүний эрх ТББ-ын Тэргүүн), Б.Батаа (ХЭҮК-ын ахлах референт), Б.Хишигсайхан (ННФ-ын менежер) нар тус тус мэдээлэл хийсэн юм.

Хуулийн төсөлд өгөх санал боловсруулахдаа НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, Хүний эрхийн хороо, Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, Хүүхдийн эрхийн хороо, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах хороо, Эрүүдэн шүүлтийн эсрэг Тусгай илтгэгчдээс Монгол Улсын Засгийн газарт эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд ирүүлсэн нийт 62 зөвлөмжийг анхааран судаллаа. Мөн Эрүүгийн загвар хууль болон одоогийн Эрүүгийн хуулийн зохицуулалттай харьцуулан судалсан судалгаа, шинжилгээ болон практик ажлын туршилагыг өргөнөөр ашиглалаа. Гэмт хэргийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд тусгасан хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, олон улсын гэрээг сахин биелүүлэх, гэрээний хороод болон НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс ирүүлсэн санал дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд онцгой ахиц дэвшил болохуйц зохицуулалт агуулж байгааг төрийн бус байгууллагууд сайшаан хэлэлцэхийн хамт хэлэлцүүлгээс гарсан санал, шүүмжийг нэгтгэн танилцуулж байна.

Гэмт хэргийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс судлаач Ц.Ариунболд, Х.Билгүүнзаяа, Ж.Даваасүрэн, М.Туяа, Монголын байгаль орчны төлөөх хуульчдын холбооноос өмгөөлөгч М.Жаргалсайхан, Ш.Жаргалсайхан, Х.Номинцэцэг, В.Ганболд, С.Оюун болон бусад ТББ-аас Ц.Батсайхан (НДЭХ-ий Төв аймгийн салбар зөвлөл), Б.Баттогтох (МонАме судалгааны төв), Ш.Гансүрэн (Ирээдүйн босго), А. Долгор (Хөгжлийн хэлхээ), Г.Итгэл (Монголын эрх зүйчдийн холбоо), Ш.Ахагвасүрэн (Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг), Т.Маамуу (Өв тэгш хөгжлийг дэмжих сан), Д.Мөнхнасан (АГБТ төв), Д.Мөнхцэцэг (Ирээдүйн босго), Д.Отгонцэцэг (Хүүхэд өмгөөлөл төв), Ц.Оюунбаатар (Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо), Д.Цэнд-Аюуш (Хууль, хүний эрх төв), Н.Шажинбат (И Эл Си нөхөрлөл), Ч.Энхмандах (Хил хязгааргүй алхам) болон Б. Хишигсайхан (Нээлттэй Нийгэм Форум) нар оролцсон юм.

- Хуулийн төслийн 1.3-р зүйлд шударга ёсны зарчмыг тогтоосон байх бөгөөд 1.3.1-д «Гэмт хэрэгт оногдуулах ял, албадагын арга хэмжээ нь тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон байна» гэх зарчмын агуулга тодорхой биш байна. Учир нь «гэмт хэрэгт нь тохирсон байна» гэдэг бол зөвхөн «зүйлчлэл»-ийг илэрхийлнэ.

- Санал:**
- 1.3.1-д заасан зарчимд хамаарах нөхцөл байдлыг тоочин заах шаардлагатай тул энэ заалтыг «Үйлдэл, эс үйлдэхүйд оногдуулах ял нь үйлдсэн гэмт хэрэг, учирсан хохирол, арга хэрэгсэл, хувийн байдалд нь тохирсон байна» гэж томъёолох;
 - Мөн хуулийн төсөлд «хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй», «гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй» гэсэн зарчмуудыг тус тус нэмэх;
 - Хуулийн төсөлд ялгаварлан гадуурхахыг хориглох зүйлийг Монгол Улсын Үндсэн хуулиас давуу, өргөн дэлгэр утгаар томъёолж оруулсан нь сайшаалтай. Гэвч тус заалтад хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан, гадуурхахыг хориглох утга ороогүй байх тул 1.3.2-т «...боловсролоор» гэснийг «боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар» гэж өөрчлөх саналтай байна.

- Хуулийн төслийн зарим зүйлд тус хуулиар тодорхойлсон зарчимд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

- Санал:**
- Гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тогтоосон байх нь ял оногдуулах үндэслэл болох тул хуулийн төслийн 5.1-д «... гэмт хэрэг үйлдсэн ...» гэсний ард «нь тогтоогдсон ...» гэж нэмэх;
 - Хүнийг хууль бусаар хорих (13.4), газрын хэвлийд халдах (24.2) гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээ нь тухайн гэмт хэргийн хор аюул, шинж байдалд тохирсон биш гэж үзэж байгаа тул хорих болон торгох ялын хэмжээг нэмэгдүүлэх;
 - Хуулийн төслийн 5.5.1-д «гэмт хэрэг үйлдэхэд ашигласан болон үйлдэж олсон багаж, хэрэгсэл, эд хөрөнгийг хураах ялыг нэмэгдэл ялын чанартай хэрэглэх» тухай нэмж оруулах;
 - Хуулийн төслийн 6.10.1-д «... арилгахаа илэрхийлсэн» гэснийг «... арилгасан бол» гэж өөрчлөх санал гаргаж байна. Учир нь хохирлоо төлөх, хор уршгийг арилгахаа илэрхийлсний төлөө тухайн этгээдэд шүүхээс ял шийтгэлийг нь хөнгөрүүлээд амлалтаа биелүүлээгүй бол шүүхээс дахин ял оногдуулахаар зохицуулжээ. Энэ нь хуулийн төслийн 1.3.5-д заасан «нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулж...» гэсэн зарчимтай зөрчилдөж байна. Мөн хуулийн төслийн 12.2.1.5, 12.3.2.1.2-т урьд нь тухайн бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсныг хүндрүүлэх нөхцөл болгон заасан нь энэ зарчимтай зөрчилдөж байна.
 - Хуулийн төслийн 8.5-д заасны дагуу «хуулийн этгээдийг татан буулгах» тохиолдолд тухайн байгууллагын ажилтнуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хэрхэх талаар зохицуулалт үгүйлэгдэж байна. Үүнийг зохицуулахгүй үлдээх нь хуулийн төслийн 1.3.3-т заасан ял, албадлагын арга хэмжээг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй гэсэн зарчимтай зөрчилдөнө.

- «Аргагүй хамгаалалт» буюу хуулийн төслийн 4.1-д халдагч этгээдийн байнгын хүчирхийлэл, дарамтад өртөж байсны улмаас өөрийнх нь эсрэг биеийн хүч хэрэглэж, эсхүл хэрэглэхийг завдаж байгаад итгэж, түүнээс хамгаалахын тулд хийсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор байна.

- Санал:** Халдагч этгээдийн байнгын хүчирхийлэл, дарамтад өртөж байсны улмаас өөрийнх нь эсрэг биеийн хүч хэрэглэж, эсхүл хэрэглэхийг завдаж байгаад итгэж, түүнээс хамгаалахын тулд хийсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх тухай заалт нэмэх саналтай байна.

- ☑ Торгох ялын мөнгөн дүнг шууд заасан нь оновчтой биш зохицуулалт гэж үзэж байгаа бөгөөд энэ нь хуулийн төслийн 1.3.2-т заасан зарчимд үл нийцнэ. Урт хугацаандаа мөнгөний ханш өөрчлөгдөх явцад тухайн гэмт хэрэгт ногдуулах торгох ял хөнгөрч байгаа бол бусад ялын тухайд энэхүү өөрчлөлт байхгүй тул нэг гэмт хэрэгт ял шийтгэл авч байгаа хүмүүст ялгамжтай байдал бий болж байна. Мөн адил гэмт хэрэг үйлдэж торгох ял авсан хүмүүст цаг хугацаанаас хамааран торгох ялын хэмжээ өөр өөр үр дагавар үүсгэхээр байгаа юм.

Санал: Тиймээс торгох ялын хэмжээг мөнгөний ханшийн өөрчлөлттэй уялдуулан зохицуулах нь зүйтэй гэж үзлээ. Мөн түүнчлэн торгох ялын хэмжээг хуулийн этгээдэд оногдуулахдаа тухайн үйл ажиллагаанаас олсон орлоготой нь уялдуулан тогтоох замаар гэмт хэрэгт оногдуулах ялын үр нөлөөг дээшлүүлэх боломжтой.

- ☑ Хуулийн төсөлд туссан «нийтэд тустай ажил хийлгэх» ялд холбоотой хэд хэдэн анхаарах зүйл байна. Нэгдүгээрт, ял эдлүүлэхгүй байх насны хязгаарыг эрэгтэй, эмэгтэй хүний хувьд ялгаатай авч үзсэн (5.7.4) нь хуулийн төслийн 1.3.2-т заасан зарчимд үл нийцнэ. Хоёрдугаарт, Хүүхдийн нас биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн хөгжилд нь харшлахгүй (7.3) нийтэд тустай ажлыг ямар субъект, хэрхэн тодорхойлох талаар тусгаагүй. Мөн энэ хэсэгт хүүхдийн нэр төр, эрхэм зэргийг анхаарч тусгах нь зүйтэй.
- ☑ Хуулийн төсөлд орсон зарим үг хэллэг, нэр томъёог Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн, үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэх шаардлагатай байна.¹

Санал:

- Тухайлбал, хуулийн төслийн 1.2.5-д «... хуулиар тусгайлан эрх олгосны дагуу хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичгийг...» гэснийг Захиргааны ерөнхий хуулийн төсөлд нийцүүлэн, хууль зүйн техникт хэрэглэж хэвшсэн «захиргааны хэм хэмжээний акт» гэж өөрчлөн найруулах;
- Мөн хуулийн төслийн 19.7-д «... дайны байдлын үед» гэснийг «... дайн болон дайн бүхий байдлын үед» гэж өөрчлөх;
- Хуулийн төслийн 5.3.2-т «...оюун ухааны хомсдлын...» гэсэн нь хүмүүсийг дорд үзсэн үг хэллэг тул, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн «оюун ухааны бэрхшээл» гэсэн үгээр солих саналтай байна.

- ☑ Хуулийн төсөлд хэрэглэсэн зарим нэр томъёог оновчтой томъёолоогүйгээс хуулийг хэрэглэх явцад хүндрэл гарч болзошгүй юм.

Санал:

- Хуулийн төслийн 11.1-д «хүнд хохирол», «хүнд гэмтэл» гэсэн нэр томъёог нэг агуулгаар хэрэглэсэн боловч өөр өөрөөр томъёолсон байгааг залруулах;
- 12.2-т «...ёс бусаар хангасан бол...» гэж заасныг илүү тодорхой томъёолох;
- 16.2.1-ийн «... согтуурах» гэсний дараа «бэлгийн, тоглоомын, хулгайн зэрэг аливаа хэлбэрээр» гэж нэмэх санал дэвшүүлж байна.

- ☑ Түүнчлэн хуулийн төслийн зарим зүйл, заалтыг найруулга, хэл зүйн хувьд засч сайжруулах шаардлагатай.

¹ Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль, 2001

- Санал:** • Тухайлбал, хуулийн төслийн 1.7.3-т «...тус улсын хүсэлтээр» гэснийг «тухайн улсад» гэж өөрчлөн найруулах;
- 3.8.1-д гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор нэгдсэн «гурав» ба түүнээс дээш хүмүүсийн тогтвортой нэгдлийг зохион байгуулалттай гэмт бүлэг гэж заасан нь «хоёр» хүн нэгдээд ашиг олох зохион байгуулалтад орохыг үгүйсгэж байгаа тул өөрчлөх;
 - 4.1.5-д аргагүй хамгаалалтын улмаас учруулсан хохирол нь халдлагын улмаас учирч болох байсан хохирлоос бага байхад хэр хэмжээг хэтрүүлсэн гэж үзэхээр зохицуулалт тул найруулгын алдааг засах шаардлагатай юм.

- ☑ Хуулийн төсөлд зарим нөхцлийг хэт ерөнхий, эсхүл субъектив байдлаар тайлбарлахаар тусгах нь зохицуулалтын хүчийг сулруулах эрсдэлтэй. Тухайлбал, хуулийн төслийн 4.5.1-д «нийтэд ашигтай зорилгод хүрэхээр хийсэн үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлыг эрсдэлээс сэрэмжлэх арга хэмжээг хангалттай авч хийсэн боловч» хохирол, хор уршиг учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй гэсэн нь учир дутагдалтай байна. Учир нь «хангалттай» гэснийг үзэмжээр хэрэглэх боломжтой.

Санал: Тиймээс «...эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг хангалттай...» гэснийг «эрсдэлийн үнэлгээний төлөвлөгөөнд тусгагдсан эрсдэлээс сэргийлэх ажиллагааг» хэмээн өөрчлөн найруулах нь илүү оновчтой гэж үзлээ.

- ☑ Мөн хуулийн төслийн 11.8-д «...гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн бол...» гэснийг хэрхэн ойлгож, хэрэглэх нь бүрхэг байна. Түүнчлэн «Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх» гэмт хэрэгт (11.8) оногдуулах торгох ял нь гэр бүлийн бусад гишүүнд дарамт учруулдаг билээ. Энэ нь тус хуулийн төслийн 1.3.3-т заасан ял, албадлагын арга хэмжээг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй гэсэн зарчимтай зөрчилдөхөд хүрнэ.

Санал: Хуулийн төслийн 11.8-ыг тодорхой томъёолох, мөн торгох ялыг ялын төрлөөс хасах саналтай байна.

- ☑ Мөн хуулийн төслийн 6.10.4 «гэм буруугаа хүлээсэн хүн хохирлоо төлөх, хор уршгаа барагдуулах талаар шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй бол ... журамлан ял оногдуулна» гэсэн заалт хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй байна.²

- ☑ «Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг аль болох бүрэн тусгах», «зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх», «хуулийн зорилт, тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд оролцогчдоос удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл, тэдгээрийг биелүүлэх журам, эрх, үүрэг, онцгойлон үзэх нөхцөл байдал, эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын төрөл хэмжээг тодорхой заасан байх»³ гэсэн хуулийн төслийн нийтлэг шаардлагад нийцүүлэх үүднээс зарим зүйл заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналтай байна.

² Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль, 2001 он, 12.1.8

³ Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль, 2001 он, 12.1.2, 12.1.5, 12.1.8

- Санал:**
- Өмч, эд хөрөнгө, сэтгэл санааны хохирлыг хуулийн төсөлд тооцож оруулаагүй байгаа тул эдгээр нөхцлийг нэмж оруулах шаардлагатай байна.
 - «Хүчиндэх» гэмт хэрэг буюу хуулийн төслийн 12.1.2-т «хуурч мэхлэх», «ураг төрлийн хүнийг» гэсэн нөхцлийг нэмж оруулах;
 - 13.1-д «... хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх...» гэснийг «... хөдөлмөрийг мөлжих...» гэж өөрчлөх санал дэвшүүлж байна.
 - Өөрөө мэдсээр байж хөлсийг нь өгөлгүй хүчээр хөдөлмөрлүүлсэн тохиолдолд «хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх» бус хүний хөдөлмөрийг мөлжсөн хэрэг болно. 13-р бүлэгт «Хүний хөдөлмөрийг мөлжих» гэсэн гэмт хэргийг нэмэх саналтай байна. Үүнийг 13.13-тай холбон үзэж, өөрчлөн найруулах боломжтой. Учир нь «нийтэд тустай ажил хийлгэх ял» бол албадан хөдөлмөрлүүлэх нэг хэлбэр гэж үзэж байна. Тиймээс «албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг» гэж оруулж ирж байгаа нь хуулийн зүйл заалтын хооронд зөрчил үүсгэж болзошгүй.
 - Хүн барьцаалах буюу 13.3, хүнийг хууль бусаар хорих буюу 13.4-ийн 13.3.2.1.1, 13.4.2.1.1-д «хөгжлийн бэрхшээлтэй хүн» гэж нэмэх саналтай байна.
 - Зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнийг зохион байгуулалттай гэмт бүлэгт элссэн үйлдэлд болон өөрийнх нь үйлдсэн гэмт хэрэгт ял оногдуулахаар (3.8.3) хуулийн төсөлд заажээ. Гэтэл зохион байгуулалттай гэмт бүлэгт элсэхийг гэмт хэрэг гэж заагаагүй тул энэ үйлдэлд ял оногдуулах нь хуулийн төслийн 5.1.1-тэй зөрчилдөж байна. Гэмт хэрэг гэж үзэх гол нөхцөл нь тухайн үйлдэл, эс үйлдэхгүйг хуулиар хориглож, гэмт хэрэгт тооцсон байх учиртай.
 - Хувь хүн, орон байрны халдашгүй дархан байдлыг хамгаалах үүднээс хуулийн төслийн 13.7-р зүйлд зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийхийг гэмт хэрэгт тооцсоныг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч авлигын эсрэг эрэн сурвалжлах сэтгүүл зүй, хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэхэд бодит саад болохыг үгүйсгэх аргагүй юм. Тиймээс энэ дутагдалтай байдлыг засч өөрчлөн найруулах саналтай байна. Мөн хуулийн төслийн 13.9 (хууль бусаар хүний захидал, харилцааны нууцад халдах), 13.10 (хувь хүний мэдээлэлд халдах), 13.11 (хувь хүний нууцыг задруулах) зүйлүүдэд тухайн гэмт хэргийн улмаас бусдад учрах хор уршгийг хэрхэн тооцох талаар тусгаагүй байна.

- Хүний цус, эд эрхтэнийг хүч хэрэглэх, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж авахыг гэмт хэрэгт тооцохоор оруулсан нь «хууран мэхэлж, залилж, албадах» замаар авах нөхцлийг орхигдуулсан гэж үзсэн тул хуулийн төслийн 15.3.1-д эдгээр нөхцлийг нэмж оруулах саналтай байна. Мөн глобальчлал тэлэхийн хэрээр туршилтад орж баталгаажаагүй эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах гэмт хэрэг гарах болсон. Гэтэл хуулийн төсөлд зөвхөн «хориглосон, хугацаа дууссан» гэсэн нөхцөл заасан нь учир дутагдалтай байна.
- Хуулийн төслийн 16.3-д «тусгай бүлгийн хүүхдийг орхисон, шунахайн сэдэлтээр өв залгамжлах эрхийг авахаар, санаатайгаар хаяж, амь насыг хохироосон» гэсэн санааг нэмэх нь зүйтэй гэж үзлээ.
- Сүүлийн жилүүдэд гэр бүлээс гадуур харилцаатай болох, ял эдлэх, өөр улсад амьдрах зэргээр хүүхдээ тэжээн тэтгэх, хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлсхийх явдал газар авч байгаа. Хүүхдийн тэтгэлгийг нэхэмжлэх гэхээр хариуцагчийн хаяг тодорхойгүй, заавал эрэн сурвалжлах хэрэг гардаг, мөн шүүхийн процесс удаан зэрэг шалтгааны улмаас хүүхдийн эрх ашиг хохирох нь түгээмэл болсон билээ. Тиймээс гэмт хэргийн тухай хуульд энэ зохицуулалтыг тусгах нь хүүхдийн өмнө хүлээх эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлэхэд чухал үүрэгтэй.

Санал: Хүүхдийн эсрэг гэмт хэргийн бүлэгт «Хүүхдээ тэжээн тэтгэхээс санаатайгаар зайлсхийх» гэмт хэргийг нэмж оруулах саналтай байна. Уг зүйлд «Төрүүлсэн болон үрчлэн авсан, дагавар хүүхдээ тэжээн тэтгэхээс санаатайгаар зайлсхийсэн бол 140.0 мянгаас 2.0 сая төгрөгөөр торгох, эсхүл зуун дөчин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэгээс зургаан сар хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсхүл нэгээс зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Хүүхдээ тэжээн тэтгэх талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс санаатай зайлсхийсэн бол зуун дөчөөс хоёр зуун наян цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл гурваас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ» гэсэн зүйл, хэсэг нэмэх санал гаргаж байна.

- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн зөвлөмж, Хүний эрхийн хороо, Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, Эрүүдэн шүүхийн эсрэг тусгай илтгэгчдээс Монгол Улсын Засгийн газарт өгсөн гол зөвлөмж⁴ бол «эрүүдэн шүүх» гэсэн тодорхойлолтыг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (ЭШЭК)-д нийцүүлэх тухай байсан. Хуулийн төслийн 21.15.1-д өгсөн эрүүдэн шүүхийн тодорхойлолт бүхэлдээ ЭШЭК-д нийцэж байгаа хэдий ч субъектийг бүрэн нийцүүлээгүй байна.

Санал: 21.15.1-д «хууль сахиулагч өөрөө» гэснийг «төрийн албан хаагч» гэж өөрчлөх саналтай байгаа бөгөөд ингэснээр буруутай бүх этгээдэд хариуцлага оногдуулах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

- Улсын тусгай хамгаалалттай газар нутагт (24.5) хууль бусаар ан агнасан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байгааг тайлбарлах нь зүйтэй. Мөн хуулийн төслийн 24.7-д болгоомжгүйгээс ой хээрийн түймэр тавьсан үед хүлээлгэх хариуцлагыг заасан ба харин санаатай тавьсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг орхигдуулжээ.

Санал: • Хуулийн төслийн 21.1.2-т заасан гэмт хэрэгт оногдуулах ялын төрөлд «эрх хасах, хязгаарлах» ялыг нэмэх;

- 24.2.1-д «... газрын хэвлийд халдсан бол», 24.2.2-т «...байгаль орчинд хохирол учирсан бол» гэсний дараа «... учирсан хохирлыг арилгуулж» гэж тус тус нэмэх, мөн хууль бусаар газрын хэвлийд халдсан бол тус гэмт хэргийг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хурааж улсын орлого болгодог байх заалт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

⁴ A/HRC/16/5, CAT/C/MNG/CO/1: 7, CCPR/C/MNG/CO/5: 13, E/CN.4/2006/6/Add.4: 55 (b)

Дугаарыг эрхэлсэн: **Б.ХИШИГСАЙХАН**
ННФ-ын Засаглалын
хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn